



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 159,800,000.00 (нэг зуун тавин есөн сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 154,103,425.90 (нэг зуун тавин дөрвөн сая нэг зуун гурван мянга дөрвөн зуун хорин таван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Төмөр замын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төмөр замын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Артур, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн нэгжийн зохицуулагч Б.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001346
12-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 05 дугаар сарын 30 ны өдрийн
 273 дугаар тогтоолын хавсралт



**БҮС НУТГИЙН АВТОЗАМ ХӨГЖҮҮЛЭХ, ЗАСВАР АРЧЛАЛТЫН ТӨСЛИЙН НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ТӨМӨР
 ЗАМЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд крузер 200, 56-08 УНУ, ЖТМНХ05J404091900	2/26/2015	159,800,000.00	154,103,425.90	5,696,574.10
	Нийт дүн		159,800,000.00	154,103,425.90	5,696,574.10
			(нэг зуун тавин есөн сая найман зуун мянга)	(нэг зуун тавин дөрвөн сая нэг зуун гурван мянга дөрвөн зуун хорин таван төгрөг ерэн мөнгө)	(таван сая зургаан зуун ерэн зургаан мянга таван зуун далан дөрвөн төгрөг арван мөнгө)